



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/296


Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймаг болон МоЭнКо ХХК хоорондын хамтран ажиллах гэрээнд хяналт тавих Хамтын ажиллагааны хорооны хуралдаанаар хэлэлцсэний дагуу Хөшөөтийн уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр тоосжилтод өртөж буй малчин өрхүүдийн судалгааг гаргах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг ханган, холбогдох тайлан мэдээллийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг ажлын хэсэг (Б.Баярсүх)-т даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн
ахлагч: **Б.Баярсүх** - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга
- Ажлын хэсгийн
гишүүд: **О.Ганцоож** - Дарви сумын Засаг дарга, аймгийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- Х.Баасанхүү** - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн
- Б.Одонбаяр** - Цэцэг сумын Засаг даргын орлогч
- Т.Жанлав** - МоЭнКо ХХК-ийн Төр, олон нийттэй
харилцах асуудал эрхэлсэн захирал
- Б.Эрдэнэбилэг** - МоЭнКо ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй
байдал, эрүүл ахуй, байгаль орчин хариуцсан
сургалтын менежер
- М.Энхмандах** - МоЭнКо ХХК-ийн Ахлах хуульч
- Б.Энхболд** - Дарви сумын Засаг даргын орлогч
- А.Энхзаяа** - Цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
- Б.Эрдэнэцэцэг** - Мэргэжлийн хяналтын газрын
орчны эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч
- Х.Мөнхжаргал** - Мэргэжлийн хяналтын газрын
Байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Б.Төгөлдөр** - Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын хэлтсийн дарга
- Нарийн бичгийн
дарга: **Б.Ариундолгор** - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
мэргэжилтэн